

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2012 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Үндсэн зүйл

Монгол Улсын Засгийн Газраас Компанийн Засаглалын Үндэсний Хөтөлбөрийг /цаашид Хөтөлбөр гэх/ баталж уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохицуулах түүнд хяналт тавих үүрэг бүхий Компанийн засаглалын үндэсний зөвлөлийг /цаашид Зөвлөл гэх/ төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор байгуулж үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Энэхүү зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа нь зөвлөлийн хурал бөгөөд өөрийн ажлын албатай. Энэ нь Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/-ны газрын нэг бөгөөд өнгөрсөн хугацаанд 1 хүнтэйгээр үйл ажиллагаа явуулж ирсэн. Албаны хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх үүднээс 1 ажилтанг санхүүжүүлэх талаар Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй ярилцан шийдвэрлэж, өнөөдөр 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2012 он гарсаар зөвлөлийн 6 удаагийн хуралдааныг зохион байгуулж зөвлөлийн хурлын дэгийн төсөл, албаны 2012 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулан зөвлөлийн гишүүдэд хүргүүлсэн. Түүнчлэн компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хагас жилийн тайланг боловсруулан Санхүүгийн зохицуулах хорооны хуралд танилцуулсан.

Хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг зөвлөлийн гишүүдэд танилцуулан саналыг авч хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулахаар байгууллага тус бүрийн хариуцан ажиллах дарга, ажилтан нартай нэг бүрчлэн уулзаж ярилцаж эцэслэн шийдвэрлэсэн.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх оролцогч байгууллагуудын оролцоог хангах зорилгоор “Үндэсний компанийн засаглалын бодлого” сэдэвт дугуй ширээний уулзалтыг төрийн болон төрийн бус байгууллагын удирдлагын түвшинд зохион байгуулж уг уулзалтаас тодорхой шийдвэрийг гаргасан.

Сургалтын байгууллагуудын сургалтын чанар стандарт харилцан адилгүй түвшинд байгаа бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаа, сургалтын чанарыг сайжруулах, нэг түвшинд хүргэхээр сургалтын хөтөлбөрийн стандарт, сургалтын журам болон сургалтын гэрээний төслийг боловсруулан СЗХ-ны хуралд танилцуулсан.

Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагууд хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд дараах үйл ажиллагаа, арга хэмжээг авч ажилласан байна.

Компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх ёс зүйг хэрэгжүүлэх эрх зүй эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх

2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хурал Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хуулийн төслийг хэлэлцэн баталсантай холбогдуулан Хорооны Үнэт цаасны газрын зүгээс дээрх хуулийг хувьцаат компаниуд, тэдгээрийн

удирдлага, хувьцаа эзэмшигчдэд сурталчлах, ухуулан таниулах, шинэ эрх зүйн зохицуулалтын талаар мэдээлэл өгөх ажлыг гүйцэтгэж ирлээ. Үүнд:

Хууль сурталчлах ажлын хүрээнд хувьцаат компаниудад хамаарах Компанийн тухай хуулийн шинэлэг зохицуулалтын талаар нийт бүртгэлтэй хувьцаат компаниудад тогтмол мэдээлэл, анхааруулга хүргүүлж ажилласан бөгөөд Хорооны цахим хуудсанд энэ талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий линк /холбоос/ нээж ажиллуулж байна.

Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт болон Мэргэшсэн үнэлгээчдийн холбоотой хамтран 120 орчим мэргэшсэн нягтлан бодогч, үнэлгээчдэд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтран орон нутгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн 50 ахлах гүйцэтгэгчид болон нийслэлийн 100 орчим шийдвэр гүйцэтгэгчдэд, Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран гишүүн байгууллагуудад, Монголын барилгын зургийн институт, Олон улсын санхүүгийн корпораци /IFC/-тай хамтран хуульчдын хүрээнд, 2012 оны 4 дүгээр сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгуулсан Хорооны орон нутгийн төлөөлөгчдийн семинар, нийт Улсын байцаагчдын сургалт зэрэг олон удаагийн уулзалт, сургалт, семинарыг 2012 оны эхний хагас жилийн хугацаанд зохион байгууллаа.

Мөн тус газрын зүгээс Компанийн тухай шинэ хуульд нийцүүлэн “Санал хураах кумулятив арга хэрэглэх тухай журам”, “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, “Хувьцаат компанийн дүрмийн үлгэрчилсэн загвар” зэргийн төслийг боловсруулж, Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулаад байна.

Одоогийн байдлаар Үнэт цаасны газар Компанийн тухай хуультай нийцүүлэн компанийн дүрмийг шинэчлэн найруулсан компаниудаас ирүүлсэн дүрмийг хянаж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт мэдээлэл хүргэн ажиллаж байгаа бөгөөд Хороонд хурлын материалаа ирүүлсэн хувьцаат компаниуд үндсэндээ шинэчилсэн дүрмээ улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээд байна.

Даатгалын газраас компанийн засаглал болон компанийн хуулийн талаар даатгалын компаниудын хүрээнд уулзалт зөвлөгөөн хийж тухайн компаниудын ТУЗ болон хувь нийлүүлэгчдийн мэдээллийг нэгтгэсэн.

Банк бус санхүүгийн байгууллагуудын компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагыг томилох үйл ажиллагааг компанийн засаглалын үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэх ажлын хүрээнд Компанийн тухай хууль болон Банк бус санхүүгийн байгууллагын тухай хуулийн 13.6-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийг үндэслэн шаардлага хангасан гүйцэтгэх удирдлагыг Төлөөлөн удирдах зөвлөл болон хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр томилон ажиллаж байна.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль 2011 оны 10 дугаар сарын 27-ны өдөр шинэчлэн батлагдсан. Хуульд хадгаламж, зээлийн хоршооны Тэргүүлэгчдийн зөвлөл, Хяналтын зөвлөл, гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага, бүрэн эрх, тэдгээрийн хүлээх хариуцлагыг зүйл тус бүрээр тусгайлан зааж өгсөн. Хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, гүйцэтгэх удирдлага нь шаардлага хангаж буй эсэхэд нь хяналт тавин ажиллаж байна.

Түүнчлэн шинэчлэн найруулсан Компанийн тухай хууль батлагдсантай холбогдуулан банк бус санхүүгийн байгууллагууд нь компанийн дүрэмд заасан төлөөлөн удирдах зөвлөл,

гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын бүрэн эрх, тэдгээрийн хүлээх үүргийг хуульд нийцүүлэн шинэчилж тусгуулахаар ажиллаж байна.

Мөн тус хуулийн 81.1, 81.2-р зүйлд заасны дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, цалин, урамшуулал болон нэр дэвшүүлэх хороодтой байж болно гэж заасан. Үүний хүрээнд Олон улсын санхүүгий корпорацитай хамтран тус хороодын жишиг дүрмийг боловсруулахаар ажиллаж байгаа бөгөөд үүнээс аудитын хорооны жишиг дүрмийн төслийг боловсруулан санал авахаар Үнэт цаасны газар хүргүүлээд байна.

Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага манлайлах

Төрийн өмчит гурван компанийг компанийн сайн засаглалтай жишиг компани болгохоор тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаагаас гадна төрийн өмчит бүх компани дээр компанийн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх эхлэлийг тавьлаа.

Энэхүү ажлын хүрээнд төрийн өмчит компаниудын гүйцэтгэх удирдлагуудтай уулзаж компанийн засаглалын талаархи ойлголтыг өгч, компани болгон дээр энэ асуудлыг дагнан хариуцах ажилтныг үндсэн ажлаас нь чөлөөлөхгүйгээр хавсран ажиллуулах арга хэмжээг авлаа. Цаашид энэ чиглэлээр дагнан ажиллах ажилтан, томоохон компани дээр удирдлагын бүтцийн нэгж байхаар зохион байгуулахаар төлөвлөж, ажиллах зарчим, үүрэг чиглэл, хүн хүч, санхүүжилт, сургалт, сурталчилгааны талаархи санал боловсруулах арга хэмжээ хамтран авч байна.

Компанийн засаглалын кодекс, бизнес ёс зүйг хэрэгжүүлэх компани, аж ахуйн нэгжийн удирдлага, менежментийг сайжруулах

Аливаа компанийн засаглалын түвшинг үнэлэх шалгуур үзүүлэлтийг бий болгож хэрэгжилтэд нь үнэлэлт дүгнэлт өгөх нь тухайн байгууллагад сайн дурын үндсэн дээр засаглалыг хөгжүүлэх гол хөшүүрэг болох тул компанийн засаглалын үнэлгээний асуудлаар үндэсний хэмжээний арга аргачлалыг боловсруулахаар холбогдох байгууллага болон олон улсын байгууллагуудын хүрээнд ярилцаж зарим байгууллага болон салбарын хүрээнд тодорхой ажлуудыг эхлүүлээд байна.

Энэхүү ажлын хүрээнд АНУ-ын хөгжлийн агентлаг, Бизнесийг дэмжих санаачлага төсөлтэй хамтран уг төслөөс эцэслэн боловсруулсан компанийн засаглалын зэрэглэлийн иж бүрэн аргачлалыг танилцуулах зорилгоор МҮХАҮТ, Монгол банк, МАОЭХ, ТӨХ, Удирдлагын академи болон Үнэт цаасны газар, Бичил санхүүгийн газар, Даатгалын газар, ЭҮССШБҮГ-уудыг хамарсан сургалтыг зохион байгууллаа.

АНУ-ын олон улсын хөгжлийн байгууллагын Бизнесийг дэмжих санаачлага төсөл хамтран хувьцаат компанийн компанийн засаглалын түвшинг тогтоох түүнийг арчлалыг боловсруулахаар СЗХ-ны Үнэт цаасны газар, Компанийн засаглалын хөгжлийн төвтэй хамтран ажиллаж байна.

МҮХАҮТ-аас аж ахуйн нэгжүүдийн компанийн засаглалын үнэлгээ хийх аргачлал боловсруулах, компанийн засаглалын зэрэглэл тогтоох чиглэлээр Олон улсын санхүүгийн корпораци /IFC/-тай хамтран ажиллахаар тохиролцож тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

ҮХШХорооноос санаачлан компанийн засаглалын жишиг, загвар компанийг бий болгох зорилготой туршилтын төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Дархан нэхий”, “Хөх ган” “Оюуны Ундраа” зэрэг хувьцаат компаниудыг тодорхой шалгуурын үндсэн дээр сонгон уг туршилтын төсөлд хамруулах санал, холбогдох материалын хамтаар АНУ-ын олон улсын

хөгжлийн байгууллагын Бизнесийн дэмжих санаачлага төсөл, Олон улсын санхүүгийн корпораци, Компанийн засаглалын хөгжлийн төвд хүргүүлж төслийг эхлүүлээд байна.

Түүнчлэн Бизнесийг дэмжих санаачлага төслийн тусламжтайгаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудын компанийн засаглалын түвшинг тогтоох аргачлалыг боловсруулан энэхүү ажлын хүрээнд 16 даатгалын компанид уг аргачлалыг танилцуулах уулзалтыг зохион байгууллаа.

Компанийн засаглалын кодекс, бизнес ёс зүйг хэрэгжүүлэхэд оролцогч талууд, тэдгээрийн төлөөллийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх

Төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн холбоод, хувьцаа эзэмшигчийн төлөөллийн байгууллагаар гүйцэтгүүлэх замаар тэдгээрийн чадавхийг бэхжүүлж, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо болон Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбоотой харилцан ойлголцлын санамж бичгийг Санхүүгийн зохицуулах хороо байгуулсан. Уг ажлын хүрээнд хадгаламж, зээлийн хоршоодын төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гүйцэтгэх удирдлагад сургалт зохион байгуулах үйл ажиллагааг Монголын хадгаламж зээлийн хоршоодын холбоо /МХЗХХ/, Монголын хоршоодлогчдын сургалт мэдээллийн төв /МХСМТ/-ээр дамжуулан гүйцэтгүүлж байна.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, тэдгээрийн төлөөллийн байгууллагад зориулсан сургалт, семинар зохион байгуулах, гарын авлага бэлтгэн хэвлүүлэх түгээхээр Банк бус санхүүгийн байгууллагуудын /ББСБ/ гүйцэтгэх удирдлага, эдийн засагч нягтлан бодогч нарт зориулсан сургалтыг зохион байгуулж иргэдэд зориулсан ББСБ, ХЗХ гарын авлагыг бэлтгэн нийт 30000 ширхэгийг хэвлүүлэн таниулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Шинэчлэгдсэн батлагдсан Компанийн тухай хуульд компанийн засаглалын зарчим дахь зарим холбогдох заалтуудаас тусгасан ба үүний нэг заалт нь компанийн ТУЗ түүний гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байхаар заасан.

Мөн сургалтын үйл ажиллагаа улам эрчимжин сургалт зохион байгуулж буй төрийн бус байгууллагуудын тоо нэмэгдэж Компанийн засаглалын хөгжлийн төвөөс гадна Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Компанийн засаглалын институт зэрэг байгууллагуудаас хот, хөдөө орон нутгийг хамарсан компанийн удирдлагуудад зориулсан компанийн засаглалын сургалтыг явуулж эхлээд байна.

Компанийн удирдлагын түвшинд компанийн засаглалын мэдлэг олгох, ТУЗ-ийн гишүүдэд гэрчилгээ олгох 16 удаагийн сургалтыг Компанийн засаглалын хөгжлийн төвөөс зохион байгуулж нийт 280 компанийн удирдах ажилтан нар хамрагдсан байна. Үүнээс 196 хүн гэрчилгээ авжээ. Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд зориулсан гарын авлага бэлтгэн гаргаж олон нийтэд танилцуулаад байна.

МАОЭНХ-ноос компанийн гүйцэтгэх удирдлага, ажил олгогчидод чиглэсэн “Компанийн засаглал”-ын сургалтуудыг 3 удаа зохион байгуулж нийт 63 оролцогчдыг хамруулж Дорноговь аймгийн хувийн хэвшлийн компанийн захиралуудад зориулан 2 өдрийн сургалт, семинарыг тус аймгийн засаг даргын тамгын газар, Ажил олгогч эздийн холбоотой хамтран зохион байгуулсан байна. Мөн Франц Монголын бизнесийн зөвлөлтэй хамтран Компанийн нийгмийн хариуцлагын семинар, 10 дугаар сард GIZ төсөлтэй хамтран 200 гаруй

хүнийг хамарсан “Компанийн нийгмийн хариуцлага” сэдэвт үндэсний форумыг тус тус зохион байгуулаад байна.

Түүнчлэн МҮХАҮТ-аас компанийн засаглалын сургалтыг явуулж байгаа бөгөөд Орхон, Дархан аймгуудад 1 удаагийн сургалтыг явуулсан байна.

Компанийн засаглалын сургалтын чанар стандарт, заах аргачлалыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага бидний өмнө тавигдаж байгаа билээ. Сургалтын заах арга, аргачлалыг дэлхийн стандартад нийцүүлэх, өнөөгийн сургагч нарын чадварыг нэмэгдүүлэхээр компанийн засаглалын сургагч багш нарт зориулсан сургалтыг Компанийн засаглалын хөгжлийн төвөөс Глобал компанийн засаглалын форумтай хамтран Улаанбаатар хотноо зохион байгуулж нийт 20 гаруй сургагч багш нарыг бэлтгэснээс гадна дотооддоо Банк санхүүгийн академитай хамтран Компанийн засаглалын сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж нийт 49 сургагч багш нарыг бэлтгээд байна.

Компанийн засаглалын ил тод нээлттэй байдлыг бий болгох мэдээллийг олон нийтэд хүргэх ажлын хүрээнд Монгол телевиз /МТВ/-тэй компанийн засаглалын талаар тодорхой цуврал нэвтрүүлгийг явуулах, компанийн засаглалын портал сайтыг мэргэжлийн хувийн байгууллагатай хамтран ажиллуулах зэрэг ажиллуудыг хийхээр ярилцсан. Энэхүү ажлын хүрээнд зөвлөлийн дарга, компанийн засаглалын холбогдох байгууллагын төлөөлөл оролцсон 3 удаагийн ярилцлагыг МТВ-тэй хамтран явуулсан байна.

Эхний удаагийн ярилцлагын үеэр Үндэсний зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүн, хөтөлбөрийн зорилго, хийгдэж буй болон цаашид хийгдэх ажлын талаар, 2 дахь удаагийн нэвтрүүлгээр Компанийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хувьцаат компаниудын болон хараат бус ТУЗ-ийн гишүүдийг томилох, дэд хороодыг байгуулах хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар мэдээлэл өгсөн бол 3 дахь удаагийн нэвтрүүлгээр хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулах, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, хувь нийлүүлэгчдийн хурлын материалыг олон нийтэд мэдээлэх талаар мэдэгдэл хийсэн. Түүнчлэн “Mongolian Economy” сэтгүүлтэй харилцан ойлголцол, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан тус сэтгүүл дээр Компанийн засаглалын байнгын буланг байгуулж түүнтэй холбоотой мэдээ мэдээлэл гаргахаар ажиллаж байгаа бөгөөд эхний удаад Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн дарга Д.Ганбаярын ярилцлага нийтлэгдээд байна.

Үндэсний хэмжээнд компанийн засаглалын өнөөгийн байдал цаашдын чиг хандлагыг хэлэлцэн тодорхойлох “Компанийн засаглалын форум”-ыг Компанийн засаглалын хөгжлийн төв, олон улсын байгууллагууд хамтран жил бүр зохион явуулдаг бөгөөд энэ удаагийн 5 дахь форумыг зохион явуулж банк санхүүгийн болон мэргэжлийн байгууллагууд оролцож санал бодлоо солилцлоо.

МХАҮТ-иас CEO Summit-2012 компанийн захирлуудын дээд хэмжээний 2-дах удаагийн чуулга уулзалт “Тогтвортой, Тэнцвэртэй, Оролцоотой хөгжлийн төлөөх түншлэл” сэдвийн дор зохион байгуулж уг чуулга уулзалтаар компанийн засаглалын асуудлуудыг хөндөж ярилцлаа.